

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Хялганат тосгоны захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** БУА-2022/132/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a></p> <p>Булган аймаг 2022 он</p>	<p>Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 7034-2580 Цахим хаяг: <a href="mailto:ankhbayard@audit.gov.mn">ankhbayard@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: <a href="mailto:enkhtsoodolj@audit.gov.mn">enkhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Г.Цэрэнлхам Утас: 7034-2495 Цахим хаяг: <a href="mailto:Tserenlkhamg@audit.gov.mn">Tserenlkhamg@audit.gov.mn</a></p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
3.4 Материаллаг байдал .....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал .....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
4. Аудитын илрүүлэлт .....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	20

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
БУА	Булган аймаг
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХГБХЗХ	Хүүхэд гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ХХК	Хариуцлагатай хувьцаат компани

## 1. Аудитын санал дүгнэлт



### БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 107

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ХЯЛГАНАТ ТОСГОНЫ  
ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА А.СОДБААТАР ТАНАА

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бугат сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020191

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

/Төгрөгөөр/

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>9,232,066.00</u></b>	<b><u>12,585,230.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	3,265,360.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	3,265,360.00
3351	Байгууллагаас авах авлага	-	3,265,360.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	9,232,066.00	9,319,870.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	323,000.00	635,000.00
35110	Тусгай зориулалттай материал	323,000.00	635,000.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	8,909,066.00	8,684,870.00
35410	Бичиг хэргийн материал	1,879,096.00	829,870.00
35420	Аж ахуйн материал	754,270.00	-
35450	Барилгын засварын материал	1,610,700.00	1,110,000.00
35460	Хүнсний материал	-	30,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,665,000.00	6,715,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>889,763,631.56</u></b>	<b><u>2,495,341,920.40</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	889,763,631.56	2,495,341,920.40
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	822,054,330.66	2,426,381,253.70
39201	Барилга, байгууламж, орон сууц	267,034,396.01	280,011,396.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(50,938,553.87)	(73,260,546.35)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	181,000,000.00	181,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(145,773,483.01)	(155,440,149.61)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	52,006,937.60	56,297,237.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,386,857.26)	(29,647,766.43)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	18,559,428.78	33,532,660.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,271,028.66)	(7,954,331.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,183,466,528.00	2,801,776,688.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(645,643,036.93)	(660,543,333.52)
39217	Ном	-	609,400.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	67,709,300.90	68,960,666.70
39301	Програм хангамж	1,490,000.00	2,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,294,699.10)	(653,333.30)
39303	Бусад биет бус хөрөнгө	67,514,000.00	67,514,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>898,995,697.56</u></b>	<b><u>2,507,927,150.40</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>3,265,360.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	3,265,360.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	3,265,360.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	3,265,360.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	3,265,360.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>898,995,697.56</u></b>	<b><u>2,504,661,790.40</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	898,995,697.56	2,504,661,790.40

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	333,949,989.50	333,949,989.50
51101	Өмч: - төрийн	333,949,989.50	333,949,989.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>463,249,264.95</b>	<b>2,069,302,777.79</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	463,249,264.95	463,636,684.95
51220	Тайлант үеийн үр дүн	-	1,605,666,092.84
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	101,796,443.11	101,409,023.11
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>898,995,697.56</u></b>	<b><u>2,507,927,150.40</u></b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>390,915,983.00</b>	<b>2,049,770,504.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>7,452,725.00</b>	<b>1,643,512,074.70</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	7,452,725.00	1,643,512,074.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,452,725.00	1,643,512,074.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,354,467.00	6,906,780.70
1200044	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгө		1,634,857,294.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	2,098,258.00	1,748,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>383,463,258.00</b>	<b>406,258,430.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	7,140,000.00	3,050,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	1,140,000.00	3,050,000.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	6,000,000.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	65,114,068.00	31,271,390.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	5,350,000.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	63,714,000.00	8,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,400,068.00	16,953,390.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	968,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	311,209,190.00	371,937,040.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	306,634,190.00	349,537,040.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	4,575,000.00	-
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	-	22,400,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>460,557,418.98</b>	<b>442,277,207.13</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>460,557,418.98</b>	<b>442,277,207.13</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	459,435,707.99	438,037,592.15
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	169,441,115.22	162,466,873.52
210101	Үндсэн цалин	109,526,912.38	118,613,758.00
210102	Нэмэгдэл	32,378,722.75	22,065,942.52

**Булган аймгийн Хялганат тосгоны захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210105	Гэрээт ажлын хөлс	27,535,480.09	21,787,173.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,402,391.79	21,306,165.54
210201	Тэтгэврийн даатгал	14,907,407.45	14,771,057.65
210202	Тэтгэмжийн даатгал	1,656,416.57	1,641,421.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,291,293.27	1,313,137.44
210204	Ажилгүйдлийн даатгал	319,039.35	318,394.78
210205	Эрүүл мэндийн даатгал	3,228,235.15	3,262,153.86
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	70,450,700.00	66,342,776.66
210301	Гэрэл, цахилгаан	8,705,600.00	8,719,676.66
210302	Түлш, халаалт	57,365,100.00	53,580,860.00
210303	Цэвэр, бохир ус	4,380,000.00	3,819,600.00
210304	Байрны түрээс	-	222,640.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,081,950.00	17,493,116.00
210401	Бичиг хэрэг	1,439,350.00	2,414,750.00
210402	Тээвэр, шатахуун	10,056,600.00	9,777,860.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,586,000.00	1,582,330.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	3,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	623,800.00
210408	Бараа материал акталсны зардал	-	94,376.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,821,600.00	22,282,300.00
210604	Урсгал засвар	5,821,600.00	22,282,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,918,200.00	1,620,000.00
210702	Дотоод албан томилолт	2,918,200.00	1,620,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	33,541,316.00	8,281,890.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	32,647,516.00	7,450,040.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	224,400.00	222,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,700.00	125,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	99,000.00
210807	Газрын төлбөр	98,700.00	385,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	142,278,434.98	137,744,470.43
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,064,591.00	72,040,570.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	84,213,843.98	65,203,900.43
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,121,710.99	4,239,614.98
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	706,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	706,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,121,710.99	3,533,014.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,121,710.99	3,533,014.98
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(69,641,435.98)</b>	<b>1,607,493,297.57</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	22,004,459.00	1,827,204.73
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	5,862,000.00	1,827,204.73
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	16,142,459.00	-
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	(22,004,459.00)	(1,827,204.73)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(91,645,894.98)</b>	<b>1,605,666,092.84</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	333,949,989.50	99,698,185.11	540,576,917.93	974,225,092.54
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>333,949,989.50</b>	<b>99,698,185.11</b>	<b>540,576,917.93</b>	974,225,092.54
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(75,229,394.98)	(75,229,394.98)
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	333,949,989.50	99,698,185.11	465,347,522.95	898,995,697.56
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	333,949,989.50	99,698,185.11	465,347,522.95	898,995,697.56
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	333,949,989.50	101,409,023.11	463,636,684.95	898,995,697.56
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,605,666,092.84	1,605,666,092.84
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	333,949,989.50	101,409,023.11	2,069,302,777.79	2,504,661,790.40

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>387,899,225.00</b>	<b>387,715,210.70</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,575,967.00</b>	<b>6,906,780.70</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	5,575,967.00	6,906,780.70
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,575,967.00	6,906,780.70
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,575,967.00	6,906,780.70
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>382,323,258.00</b>	<b>380,808,430.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	6,000,000.00	-
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	6,000,000.00	-
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	65,114,068.00	31,271,390.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	5,350,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	63,714,000.00	8,000,000.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,400,068.00	16,953,390.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	968,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	311,209,190.00	349,537,040.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	306,634,190.00	349,537,040.00
132002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	4,575,000.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>375,679,225.00</u></b>	<b><u>353,013,110.70</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b><u>375,679,225.00</u></b>	<b><u>353,013,110.70</u></b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b><u>374,557,514.01</u></b>	<b><u>348,773,495.72</u></b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	169,441,115.22	162,466,873.52
210101	Үндсэн цалин	109,526,912.38	118,613,758.00
210102	Нэмэгдэл	32,378,722.75	22,065,942.52
210105	Гэрээт ажлын хөлс	27,535,480.09	21,787,173.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	21,402,391.79	21,306,165.54
210201	Тэтгэврийн даатгал	14,907,407.45	14,771,057.65
210202	Тэтгэмжийн даатгал	1,656,416.57	1,641,421.81
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,291,293.27	1,313,137.44
210204	Ажилгүйдлийн даатгал	319,039.35	318,394.78
210205	Эрүүл мэндийн даатгал	3,228,235.15	3,262,153.86
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	70,450,700.00	66,120,136.66
210301	Гэрэл, цахилгаан	8,705,600.00	8,719,676.66
210302	Түлш, халаалт	57,365,100.00	53,580,860.00
210303	Цэвэр, бохир ус	4,380,000.00	3,819,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	13,456,100.00	14,622,530.00
210401	Бичиг хэрэг	1,813,500.00	1,613,500.00
210402	Тээвэр, шатахуун	10,056,600.00	7,956,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,586,000.00	1,582,330.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	3,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	470,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	500,000.00	500,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,821,600.00	22,620,400.00
210604	Урсгал засвар	5,821,600.00	22,620,400.00

<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,918,200.00	1,620,000.00
210702	Дотоод албан томилолт	2,918,200.00	1,620,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,518,416.00	9,032,890.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,624,716.00	8,201,040.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	224,300.00	222,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,700.00	125,700.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	99,000.00
210807	Газрын төлбөр	98,700.00	385,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	80,048,991.00	50,484,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	80,048,991.00	49,984,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	500,000.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,121,710.99</b>	<b>4,239,614.98</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	706,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	706,600.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,121,710.99	3,533,014.98
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,121,710.99	3,533,014.98
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>(1,645,000.00)</u></b>	<b><u>34,702,100.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>1,645,000.00</b>	<b>34,702,100.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,645,000.00</b>	<b>34,702,100.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	1,645,000.00	34,702,100.00
222001	Тоног төхөөрөмж	1,645,000.00	6,200,000.00
223001	Бусад хөрөнгө	-	28,502,100.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(1,645,000.00)</u></b>	<b><u>(34,702,100.00)</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		(0.00)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
-----	----------	------------	-----------	-----------	------

	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	360,985,200.00	356,443,820.70	4,541,379.30	98.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	355,985,200.00	321,741,720.70	34,243,479.30	90.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	355,985,200.00	320,767,465.72	35,217,734.28	90.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,592,400.00	162,466,873.52	8,125,526.48	95.24
210101	Үндсэн цалин	111,137,700.00	118,613,758.00	(7,476,058.00)	106.73
210102	Нэмэгдэл	36,360,900.00	22,065,942.52	14,294,957.48	60.69
210105	Гэрээт ажлын хөлс	23,093,800.00	21,787,173.00	1,306,627.00	94.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,030,000.00	21,306,165.54	1,723,834.46	92.51
210201	Тэтгэврийн даатгал	16,206,400.00	14,771,057.65	1,435,342.35	91.14
210202	Тэтгэмжийн даатгал	1,705,900.00	1,641,421.81	64,478.19	96.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,364,700.00	1,313,137.44	51,562.56	96.22
210204	Ажилгүйдлийн даатгал	341,200.00	318,394.78	22,805.22	93.32
210205	Эрүүл мэндийн даатгал	3,411,800.00	3,262,153.86	149,646.14	95.61
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,121,500.00	66,120,136.66	1,363.34	100.00
210301	Гэрэл, цахилгаан	8,660,000.00	8,719,676.66	(59,676.66)	100.69
210302	Түлш, халаалт	53,581,500.00	53,580,860.00	640.00	100.00
210303	Цэвэр, бохир ус	3,880,000.00	3,819,600.00	60,400.00	98.44
2104	Хангамж, бараа материалын зардал	15,156,000.00	14,622,530.00	533,470.00	96.48
210401	Бичиг хэрэг	1,613,500.00	1,613,500.00		100.00
210402	Тээвэр, шатахуун	7,956,500.00	7,956,500.00		100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,586,000.00	1,582,330.00	3,670.00	99.77
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,000,000.00	3,000,000.00		100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	470,200.00	529,800.00	47.02
2105	Нормативт зардал	500,000.00	500,000.00		100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00		100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,667,700.00	14,620,400.00	17,047,300.00	46.17
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00		4,000,000.00	
210602	Тавилга	9,800,000.00		9,800,000.00	
210604	Урсгал засвар	17,867,700.00	14,620,400.00	3,247,300.00	81.83

**Булган аймгийн Хялганат тосгоны захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2107	Томилолт, зочны зардал	2,037,600.00	1,620,000.00	417,600.00	79.51
210702	Дотоод албан томилолт	2,037,600.00	1,620,000.00	417,600.00	79.51
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,280,000.00	1,558,850.00	1,721,150.00	47.53
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	324,000.00		324,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	224,300.00	222,150.00	2,150.00	99.04
210804	Тээврийн хэрэгслийн татвар	125,700.00	125,700.00		100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.00	99,000.00	22,000.00	81.82
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,100,000.00		2,100,000.00	
210807	Газрын төлбөр	385,000.00	385,000.00		100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,600,000.00	37,952,510.00	5,647,490.00	87.05
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	43,100,000.00	37,452,510.00	5,647,490.00	86.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	500,000.00	500,000.00		100.00
22	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	5,000,000.00	34,702,100.00	(29,702,100.00)	694.04
	Дотоод эх үүсвэрээр	5,000,000.00	34,702,100.00	(29,702,100.00)	694.04
223001	Бусад хөрөнгө	5,000,000.00	28,502,100.00	(23,502,100.00)	570.04
1	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	360,985,200.00	356,443,820.70	4,541,379.30	98.74
131	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	25,196,000.00		25,196,000.00	
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	25,196,000.00		25,196,000.00	
132	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	329,089,200.00	349,537,040.00	(20,447,840.00)	106.21
132001	Орон нутгийн төсвөөс	329,089,200.00	349,537,040.00	(20,447,840.00)	106.21
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	6,700,000.00	6,906,780.70	(206,780.70)	103.09
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,700,000.00	6,906,780.70	(206,780.70)	103.09
2	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00		100.00
3	Төсвийн байгууллага	1.00	1.00		100.00
5	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	18.00	18.00		100.00
6	Удирдах ажилтан	2.00		2.00	

7	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00	100.00
8	Үйлчлэх ажилтан	3.00	3.00	100.00
24	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	18.00	18.00	100.00
25	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	6.00	6.00	100.00
33	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	9.00	100.00
35	Улс төрийн албан хаагч (УТ)	3.00	3.00	100.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		31,271,390.00	(31,271,390.00)	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ		31,271,390.00	(31,271,390.00)	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		28,006,030.00	(28,006,030.00)	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		8,000,000.00	(8,000,000.00)	-
210604	Урсгал засвар		8,000,000.00	(8,000,000.00)	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		7,474,040.00	(7,474,040.00)	-
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		7,474,040.00	(7,474,040.00)	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		12,531,990.00	(12,531,990.00)	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		12,531,990.00	(12,531,990.00)	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		3,265,360.00	(3,265,360.00)	-
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		3,265,360.00	(3,265,360.00)	-
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		31,271,390.00	(31,271,390.00)	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		31,271,390.00	(31,271,390.00)	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		5,350,000.00	(5,350,000.00)	-
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		8,000,000.00	(8,000,000.00)	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		16,953,390.00	(16,953,390.00)	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		968,000.00	(968,000.00)	-

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хялганат тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд санхүүгийн тайлангийн толилуулга, тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Хялганат тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/14 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

2021-2021 онд “Хялганат шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийг баримтлан, 2022 онд иргэдээ дээдэлсэн, бүтээлч, чадварлаг төрийн захиргааны байгууллага болох зорилго дэвшүүлэн, 77 зорилтын хүрээнд 145 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна. Зорилго, зорилтоо хэрэгжүүлэхийн тулд дараах чиглэлийг баримтлан ажиллажээ. Үүнд:

1. Хүний хөгжлийн бодлого,
2. Эдийн засгийн бодлого,
3. Ногоон хөгжлийн бодлого,
4. Засаглалын бодлого,
5. Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” гэж заасны дагуу тайлант онд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажиллаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хялганат тосгоны Захирагчийн ажлын албаны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдлийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн 460,557.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,605.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 3,223.9 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хялганат тосгоны Захирагчийн ажлын алба 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 40.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	3,265.3	3,265.3
Бараа материал	9,232.1	9,319.8	87.7
Үндсэн хөрөнгө	889,763.6	2,495,341.9	1,605,578.3
<b>Нийт хөрөнгө</b>	<b>898,995.7</b>	<b>2,507,927.0</b>	<b>1,608,931.3</b>
Богино хугацаат өр төлбөр	-	3,265.3	3,265.3
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	898,995.7	2,504,661.7	1,605,666.0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>898,995.7</b>	<b>2,507,927.0</b>	<b>1,608,931.3</b>

Тайлант хугацаанд орон нутгийн төсвөөс 349,537.4 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 31,271.4 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 6,906.8 мянган төгрөг нийт

387,715.2 мянган төгрөгийн санхүүжилтийг авч 384,182.2 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулан, 3,533.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Авлага тайлант хугацаанд 3,265.3 мянган төгрөгөөр нэмэгдэж үлдэгдэлтэй байгаа нь төрөөс хариуцах цэвэр бохир усны төлбөрийн хөнгөлөлт, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор урьдчилан сэргийлэх зардлын үлдэгдлийг харилцагч газруудтай тооцооны үлдэгдлийн баталгаа үйлдээгүйгээс шалтгаалж нэмэлт санхүүжилтийн дансанд авлага үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 9,319.8 мянган төгрөг болж 87.7 мянган төгрөгөөр өссөн нь 00 суултуур, волейбол, сагсны өмсгөл, тамирын хувцас зэргийг бэлтгэж нөөцөлсөн байна. Тайлант хугацаанд орон нутгийн хөгжлийн сангаас 20,000.0 мянган төгрөгийн 49 ширхэг гэрэлтүүлэг, 2,400.0 мянган төгрөгийн төгрөгийн биеийн тамирын хувцас, өмсгөлийг шилжүүлэн авч, бичиг хэргийн материал данснаас 32 ширхэг номыг үндсэн хөрөнгийн номын фонд дансанд шилжүүлсэн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,495,341.9 мянган төгрөг болж 1,605,578.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр цагдаагийн кубон, машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, программ хангамж, бусад эд хөрөнгийг бэлтгэж, мөн улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн дулааны шугам, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн захирагчийн ажлын албаны байрны дотор гадар камер, Шинэ хөдөө төслийн хөрөнгөөр хийгдсэн чацаргананы талбай, бараа материалын тайлангаар номын фонд зэргийг шилжүүлэн авч, акталсан хөрөнгийг данснаас хассанаас шалтгаалжээ.

Өглөг тайлант хугацаанд 3,265.3 мянган төгрөгөөр нэмэгдэж үлдэгдэлтэй байгаа нь төрөөс хариуцах цэвэр бохир усны төлбөрийн хөнгөлөлтийн үлдэгдлийг Долоон бар ХХК-д, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор урьдчилан сэргийлэх зардлын үлдэгдлийг сүргийн нуга ХХК-тай тооцоо үлдэгдлийн баталгаа үйлдээгүйгээс шалтгаалсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү 2018 онд дахин үнэлгээ хийгдсэн хоёр сейфыг акталснаас үүссэн 387.4 мянган төгрөгийг дахин үнэлгээний зөрүү дансанд бууруулах бичилт хийж, тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 2,069,302.7 мянган төгрөг байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 641,073.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 90,572.5 мянган төгрөгөөр бууруулж 550,500.9 мянган төгрөгөөр баталсан байна. Улсын төсвөөс санхүүжилтийг 411,929.5 мянга, орон нутгийн санхүүжилтийг 138,571.4 мянган төгрөгөөр баталжээ. Төсвийн тодотголоор улсын төсвийн санхүүжилтийг 149501.1 мянган төгрөгөөр бууруулан, орон нутгийн санхүүжилтийг 58,928.6 мянга төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн 6 чиглэлийн арга хэмжээг санхүүжүүлэхээр оны эхний үлдэгдлээс 25,196.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 329,089.2 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 6,700.0 мянган төгрөгийн нийт 360,985.6 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 349,537.0 мянган төгрөгийн санхүүжилтийг бүрэн авч, 6,906.7 мянган төгрөгийн өөрийн орлогыг төрийн банкны түрээсийн орлогоос бүрдүүлэн, урсгал үйл ажиллагаанд 352,910.8 мянган төгрөгийг зарцуулж, 3,533.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 356,443.8 мянган төгрөг буюу 98.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал 8,125.5 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал 1,723.8 мянган төгрөгөөр буюу 7.5 хувиар, хангамж, бараа материалын зардал 533.7 мянган төгрөгөөр буюу 3.5 хувиар, томилолт зочины зардал 417.6 мянган төгрөгөөр буюу 52.5 хувиар тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орлого дараах эх үүсвэрээс бүрдсэн байна. Үүнд:

- Нэр бүхий 17 иргэнээс 5,350.0 мянган төгрөгийн хандиваар,
- Ford 4004 БУА авто машины засварын зардалд 8,000.0 мянган төгрөг, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор урьдчилан сэргийлэх зардалд 5,000.0 мянган төгрөг нийт 13,000.0 мянган төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс,
- Төрөөс хариуцах цэвэр бохир усны төлбөрийн хөнгөлөлт 10,833.4 мянган төгрөгийг Булган мээж ХХК-иас,
- Нэр бүхий 10 өрхийн хүнсний дэмжлэгт 500.0 мянган төгрөгийг, ХГБХЗХөгжлийн газраас,
- Хамтарсан багийн санхүүжилт 300.0 мянган төгрөгийг аймгийн ИТХ-аас,
- Хагас жилийн мал тооллогын зардалд 319.9 мянган төгрөгийг Статистикийн хэлтсээс,
- Ковидын шинж тэмдэг илэрч тусгаарлалтын байранд байрласан 21 иргэнээс 968.0 мянган төгрөгийг төлсөн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 5,350.0 мянган төгрөг, ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 8,000.0 мянган төгрөг, Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 16,953.4 мянган төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 968.0 мянган төгрөг нийт нийт 31,271.4 мянган төгрөгийн орлого хүлээн авч, урсгал засварын зардлаар 8,000.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаар 12,531.9 мянган төгрөг нийт 28,006.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Үндсэн хөрөнгийн 39201, 39203, 39205, 39207, 39214 дансанд 34 нэр төрлийн 677,868.1 мянган төгрөгийн хөрөнгө эзэмшилдээ байгаа элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нөхсөн хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох шаардлагатай байна. Үлдэх өртөг тэг үлдэгдэлтэй ашиглалтын хугацаа бүрэн дууссан хөрөнгөнд нэмж

элэгдлийн зардал байгуулагдахгүйгээс тухай тайлант хугацааны элэгдлийн зардал үнэн зөв илэрхийлэгдэхгүй дутуу тайлагнагдаж байна.

Мөн нэмэлт санхүүжилтийн данс болон үндсэн үйл ажиллагааны зориулалтаас бусад арга хэмжээний зардлыг зарцуулахдаа зардлын эдийн засгийн ангиллаар зарцуулахаар зарцуулалтын эрх олгоогүйгээс шалтгаалж, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн зардал, бараа материал, үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн дүнтэй зөрүүтэй илэрхийлэгдэж байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийсэн бөгөөд нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгаж тусгасан.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 128 мэдээллийг хугацаанд нь оруулсан ба сар бүр 96 мэдээлэл, улирал бүр 4 мэдээлэл оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж баталгаажуулав. Үүнд:

- ✚ Шилэн дансны нэгдсэн [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлээгүй нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,

- ✚ Мэдээллийн технологийн аюулгүй байдал, санхүүгийн программд нэвтрэх эрхийн хязгаарлалтын талаар албан ёсны шийдвэр гаргаж баталгаажуулаагүй нь мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй,

- ✚ Дотоод хяналтын журам боловсруулж мөрдөөгүй, санхүүгийн үйл ажиллагаа, өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад тавих дотоод хяналт хангалтгүй нь дотоод хяналтын талаарх Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

Аудитаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүн болох 360,985.6 мянган төгрөгөөс 10 хувь буюу 36,098.6 мянган төгрөгийн хэмнэлт гаргахаар төлөвлөж тооцоогүй нь МУЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д ".....батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасан шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 төлбөрийн актыг хугацаанд нь төлбөрийн актыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын орлогын 100040051005 дансанд төвлөрүүлсэн байна. Хэрэгжилтийг Тосгоны захирагчийн 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 01/70 дугаар албан тоотой ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өөрийн эзэмшилдээ байгаа боловч хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртөгөө бүрэн нөхсөн ашиглалтын хугацаа дууссан ч ашиглагдаж байгаа хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн шинэчлэн тогтоох, нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулалтын эрх нээхдээ Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хэрэгжүүлж ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,911,626.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,658,427.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 253,199.1 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн үр дүнгийн тайланд 1,656,888.7 мянган төгрөгийн, мөнгөн гүйлгээний тайланд 1,538.3 мянган төгрөгийн, нийт 1,658,427.0 мянган төгрөгийн алдааг тусгаж баталгаажуулав. Үүнд:

- ✚ Орон нутгийн хөгжлийн сангаас хийгдсэн үнэ төлбөргүй авсан тоног төхөөрөмж – 3,050.0 мянган төгрөг,
- ✚ Худалдан авсан авсан тавилга эд хогшил – 1,538.3 мянган төгрөг,
- ✚ Бусад хангамжийн материалын зардал – 23,102.8 мянган төгрөг,
- ✚ Цалингийн зардал – 10,670.0 мянган төгрөг,
- ✚ Бусад үндсэн хөрөнгө – 1,620,065.9 мянган төгрөг,

Энэ нь УСНББОУС 27-д “санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, “Үнэн зөв толилуулга” нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг”, НББОУС 8-ын 10.Б.1-д “аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, санхүүгийн гүйцэтгэл ба мөнгөн гүйлгээг үнэн зөв илэрхийлэх” заалтуудтай нийцэхгүй, “эрх ба үүрэг”, “үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангаагүй байна.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй болно.

### 4.3 Албан шаардлага

4.3.1 Тавилга, багаж техникийн худалдан авах зардлаас 18 нэр төрлийн 18,672.3 мянган төгрөгийн ширээ сандал, кресль сэйф шкаф зэргийг конторын тавилга бэлтгэсэн байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэхь заалтыг хэрэгжүүлээгүй, "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгаад Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаагүй хөрөнгө бэлтгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлээ.

4.3.2 Цалингийн зардлаас таван сая төгрөгөөр дээш үнийн дүнтэй орлогын 234,526,822.0 төгрөгийн 14 гүйлгээний мэдээлэл мэдээлээгүй, 2 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан

байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг"-д заасныг тус тус хэрэгжүүлээгүйд шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах, шилэн дансанд хугацаанд нь мэдээллийг иж бүрэн байршуулж, гарсан зөрчлийг таслан зогсоох албан шаардлагыг тус тус хүргүүлнэ.

#### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### **1. Бараа материал данстай холбоотой асуудал**

###### **1.1. Илрүүлэлт:**

Бичиг хэргийн материалын тайлангийн бичиг хэргийн материал дансанд аж ахуйн материал болон дугаарлагч, нуруулдагч, үдэгч, тамга зэрэг үлдэгдэлтэй байна. Энэ нь УСНББОУС 17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэсэн заалт болон "ангилал" батламж мэдэгдлийг хэрэгжүүлээгүй байна.

###### **1.2. Өгсөн зөвлөмж:**

УСНББОУС 17, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д "Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх.

##### **2. Төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудал**

###### **2.1. Илрүүлэлт:**

Батлагдсан төсөвт зардлын дүн 360,985.6 мянган төгрөгөөс 10 хувь буюу 36,098.5 мянган төгрөгийн хэмнэлт гаргахаар төлөвлөж тооцоогүй байна.

###### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоол болон МУЗГ-аас баталсан төсвийн хэмнэлтийн талаар авч хэрэгжүүлж байгаа шийдвэрүүдийг мөрдөж ажиллах

##### **3. Дотоод хяналттай холбоотой асуудал**

###### **3.1. Илрүүлэлт:**

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам" гэж заасны дагуу 2020-2021 хичээлийн жилд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж ажиллаагүй байна.

###### **3.2. Өгсөн зөвлөмж:**

МУЗГ-ын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам боловсруулж, дотоод хяналт шалгалтын баг томилуулан ажиллуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
1	Хялганат тосгоны Захирагчийн ажлын алба	9	1,911,626.1	5	1,658,427.0	0	0	2	253,199.1	2	0